



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/75

Хөхбүрд

Алтан намар 2023 үзэсгэлэн  
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Алтан намар 2023” үзэсгэлэн худалдаанд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Ганцоож (Засаг даргын Орлогч)

Гишүүд: Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Ж.Ёндонпил (Тархвар зүйч)

Ө.Ариунзаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Л.Алимаа (Нягтлан бодогч)

2.Үзэсгэлэн худалдааг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр чанартай зохион байгуулахыг Хөдөө аж ахуйн Тасгийн дарга (Л.Гүндцамба)-д хариуцуулсугай.

3.Алтан намар 2023 үзэсгэлэн худалдаанд зарцуулагдах 1 000 000 (Нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д, Нягтлан бодогч (Л.Алимаа) нарт зөвшөөрсүгэй.

4.Дээрх ажлыг чанартай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын Орлогч (Г.Ганцоож)-д даалгасугай.



642301157